



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан.

Аудитын код: СНАГ-2025/16/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn
Аудитор: П.Ариунзаяа
Утас: 261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨДӨӨ АЖ АХУЙН КОРПОРАЦИ
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЦОГТСАРАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 07/1026
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Тайлант жилийн үрийн болон тэжээлийн улаанбуудайн борлуулалтын гэрээний үүргийн биелэлтээс шалтгаалж нийт 7,823.7 сая төгрөгийн авлага гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүй;
- Гурилын үйлдвэрт борлуулсан 7402 тн хүнсний улаанбуудайн үнэ 7,273.0 сая төгрөг гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүйгээс шүүхийн маргаан үүссэн;
- Хугацаа хэтэрсэн өр төлбөрт 1,412.2 сая төгрөгийн газар, үл хөдлөх хөрөнгө хүлээн авч, зээлдэгчээс авах авлагын дүнг бууруулсан боловч, эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлээгүй, мөн 519.2 сая төгрөгийн машин, механизм, автотээврийн хэрэгсэл хүлээн авсныг хөрөнгийн орлогоор бүртгэж, харилцагчийн авлагыг бууруулаагүй;
- "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах" ӨТБГ-23/01 дугаартай санхүүгийн түрээсийн гэрээний хугацаа хэтэрсэн 29,489.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй;
- "Хөдөө Аж Ахуйн бага оврын трактор худалдан авах", "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээний үндсэн зээлийн 98,398.8 сая төгрөгийн, хүүгийн төлбөрийн 18,280.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй;

- "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-ийн дамжуулан зээлийн гэрээний 2024 онд төлөх үндсэн зээлийн 7,234.9 сая төгрөг, хүүгийн 3,798.3 сая төгрөгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй;
- Тус компани тайлант жил шинээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, шилмэл үүлдэрийн үхэр худалдан авах 9,110.9 сая төгрөгийн шууд гэрээг гадаадын 7, дотоодын 1 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулж, гүйцэтгэсэн;
- Дотоодын аж ахуйн, нэгж байгууллагаас 6046 тн үрийн улаанбуудайн 9,279.0 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн;
- Үржлийн үхэр худалдан авах гэрээний хэрэгжилттэй холбоотой 1,170.3 сая төгрөгийн урьдчилгааны төлбөрийн үлдэгдэлтэй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 35 дугаар зүйлийн 35.1, 35.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 48 дугаар зүйлийн 48.7, Өрийн удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Засгийн Газрын 2021 оны 394 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн дүрэм"-ийн 4.3 дахь заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны "Төрийн өмчийн хөрөнгийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 152 дугаар тогтоолоор "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-д бүртгэлтэй "Алтандорнод Монгол" ХХК-аас улсын төсвийн татварын өрөнд хураан авсан үйлдвэрлэлийн бааз, нефть бүтээгдэхүүний агуулах, контор, үйлчилгээний барилга, нийт 57,173.4 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах" шийдвэрийг гаргасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т Төвийн бүсийг "Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс" болгон төрөлжүүлэн хөгжүүлэх, "Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх" бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхээр тусгасан байна.

Мөн Засгийн Газрын 2024 оны 38 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулан, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”-ээр тогтоосон байна. Уг тогтоолтой холбогдуулан Засгийн газрын 2024 оны 32 дугаар хуралдааны тэмдэглэлээр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн, үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг гаргасны дагуу “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн төв салбар 2024 оны 10 дугаар сард Дархан-Уул аймгийн Дархан суманд шилжин суурьшиж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор ажилтнуудын орон сууцны дэмжлэгийн зардалд 1,134.8 сая төгрөг, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын тэтгэмжийн зардалд 89.4 сая төгрөг, тавилга, эд хогшил, компьютер тоног төхөөрөмж худалдан авахад 191.4 сая төгрөг, нүүлгэлтийн ачаа, тээврийн зардалд 26.8 сая төгрөг, бусад зардалд 22.1 сая төгрөг, нийт 1,464.5 сая төгрөгийг тайлант онд зарцуулсан байна.

Бусад асуудал

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК нь 2024 онд үйл ажиллагаандаа 12 модуль бүхий одоо ERP системийг нэвтрүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,862,025,240.45	892,209,987.46
1.1.2	Дансны авлага	194,105,162,045.79	177,921,471,533.92
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	145,165,315.68	146,807,792.78
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	65,227,341,802.39	104,192,240,534.10
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	262,339,694,404.31	283,152,729,848.26
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	57,697,021,299.74	56,858,915,262.39
1.2.2	Биет бус хөрөнгө	22,402,909,623.46	22,402,909,623.46
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	80,099,930,923.20	79,261,824,885.85
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	342,439,625,327.51	362,414,554,734.11
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	77,162,226,182.83	75,727,241,846.41
2.1.1.2	Цалингийн өглөг	1,996,659.10	3,095,100.92
2.1.1.3	Татварын өр		0.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	351,440.24	7,229,929.55
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	0	0.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	18,305,466,841.88	22,078,862,991.98
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	436,309,349.77	431,644,622.77
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	463,334,571.90	440,334,571.90
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	96,369,685,045.72	98,688,409,063.53
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл	174,000,599,056.44	169,482,548,006.03
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	174,000,599,056.44	169,482,548,006.03
2.2	Өр төлбөрийн нийт дүн	270,370,284,102.16	268,170,957,069.56
2.3	Эздийн өмч		
2.3.1	төрийн	81,130,221,166.51	81,130,221,166.51
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	13,162,475,821.95	13,162,475,821.95
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-22,223,355,763.11	-22,143,046,759.80
2.3.10	Хуримтлагдсан ашиг тайлант үеийн	0	22,093,947,435.89
2.3.12.	Эздийн өмчийн дүн	72,069,341,225.35	94,243,597,664.55
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	342,439,625,327.51	362,414,554,734.11

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,200,347,946.99	50,502,061,764.06
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	11,014,641,682.10	49,360,555,656.31
3	Нийт ашиг (алдагдал)	1,185,706,264.89	1,141,506,107.75
4	Түрээсийн орлого	765,152,064.20	3,640,650,101.52
5	Хүүний орлого	741,587,770.78	1,822,929,882.54
6	Ногдол ашгийн орлого		0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого		0.00
8	Бусад орлого	118,160,398,288.95	36,665,153,866.75
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,183,920,074.69	4,924,343,298.74
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,440,989,438.17	10,027,980,604.51
11	Санхүүгийн зардал	3,491,882,927.01	3,951,162,348.33
12	Бусад зардал	2,500,000,000.00	2,043,833,708.37
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5,773,283,394.79	227,992,463.03
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		980,099.69
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	987,072,799.60	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	101,475,695,754.56	22,093,947,435.89
19	Орлогын татварын зардал	-	
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	101,475,695,754.56	22,093,947,435.89
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	101,475,695,754.56	22,093,947,435.89
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	
23.3	Бусад олз (гарз)	-	
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	101,475,695,754.56	22,093,947,435.89
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	34,919,323,596.63	70,527,884,853.94
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	21,183,194,503.26	33,679,676,513.17
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	316,902,128.78	
1.1.6	Бусад мөнгөн орлого	13,419,226,964.59	36,848,208,340.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,986,462,156.18	63,384,920,354.61
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,747,414,442.96	3,862,301,285.84
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	523,032,517.16	1,075,007,362.87
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	82,966,627.60	47,864,135,513.89
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	231,447,688.67	523,344,996.20
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	61,334,130.00	456,576,958.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	86,420,519.95	127,108.19
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	1,319,389,504.58
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	488,460.00	702,850.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	29,253,357,769.84	8,283,334,775.04
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,932,861,440.45	7,142,964,499.33
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	126,518,895.17
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		126,518,895.17
2.2	Мөнгөн зарлагын дүн	70,836,200.00	1,471,170,048.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	70,836,200.00	1,471,170,048.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-70,836,200.00	(1,344,651,152.83)
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	7,643,599,145.36
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		7,643,599,145.36
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(7,643,599,145.36)
4	Валютын ханшийн зөрүү		(124,529,454.13)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,862,025,240.45	(1,969,815,252.99)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,862,025,240.45
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,862,025,240.45	892,209,987.46

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0	0	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	81,130,221,166.51	0		13,162,475,821.95	-123,699,051,517.67	-29,406,354,529.21
3	Залруулсан үлдэгдэл	0	0	0	0	0	0
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	101,475,695,754.56	101,475,695,754.56
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0
6	Өмчид гарсан өөрчлөлт					0	0
7	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0	0
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0		0	0
1	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	81,130,221,166.51	0		13,162,475,821.95	-22,223,355,763.11	72,069,341,225.35
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	80,309,003.31	80,309,003.31
3	Залруулсан үлдэгдэл	81,130,221,166.51	0	0	13,162,475,821.95	-22,143,046,759.80	72,149,650,228.66
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	22,093,947,435.89	22,093,947,435.89
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0
6	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	0	0
7	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0	0
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0
9	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	81,130,221,166.51	0		13,162,475,821.95	-49,099,323.91	94,243,597,664.55

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь		
1	Улаанбуудайн нөөц бүрдүүлэлт		тн	81,700.0	57,284.7	24,415.3	70.1	
	1.1.	Хүнсний улаанбуудай	- Өр авлагад	тн	22,700.0	16,298.3	6,401.7	71.8
			- Худалдан авах	тн	51,000.0	33,230.2	17,769.8	65.2
		Нийт		тн	73,700.0	49,528.5	24,171.5	67.2
	1.2.	Үрийн буудай	- Өр авлагад	тн	2,000.0	1,032.9	967.1	51.6
			- Худалдан авах	тн	6,000.0	6,723.3	(723.3)	112.1
	Нийт		тн	8,000.0	7,756.2	243.8	97.0	
2	Нийт орлого		мян.төг	99,981,684.1	56,603,298.7	43,378,385.4	56.6	
	2.1.	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	72,764,123.4	50,502,061.7	22,262,061.7	69.4	
	2.2.	Туслах үйл ажиллагааны орлого	мян.төг	27,217,560.7	6,101,237.0	21,116,323.7	22.4	
3	Нийт зардал		мян.төг	99,801,372.7	64,312,879.6	35,488,493.0	64.4	
	3.1.	Цалин, хөлс	мян.төг	4,487,305.0	4,487,305.0	-	100.0	
	3.2.	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	594,255.8	577,872.4	16,383.4	97.2	
	3.3.	Байр ашиглалтын зардал	мян.төг	572,251.6	526,298.9	45,952.7	92.0	
	3.4.	Хангамж, бараа материал	мян.төг	776,567.5	166,973.7	609,593.8	21.5	
	3.5.	Норматив зардал	мян.төг	68,920.0	58,480.0	10,440.0	84.9	
	3.6.	Эд хогшил, урсгал засвар	мян.төг	808,453.8	467,503.6	340,950.2	57.8	
	3.7.	Томилолт	мян.төг	811,100.6	772,023.9	39,076.7	95.2	
	3.8.	Ажил үйлчилгээ	мян.төг	3,726,288.8	3,797,189.5	(70,900.8)	101.9	
	3.9.	Борлуулсан барааны өртөг	мян.төг	83,418,483.6	49,360,555.7	34,057,927.9	59.2	
	3.10.	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	мян.төг	1,618,000.0	1,446,929.6	171,070.4	89.4	
	3.11.	Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг	2,919,746.10	2,651,747.4	267,998.7	90.8	
4	4.1.	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	180,311.4	(7,709,580.9)	7,889,892.3	(4,275.7)	
	4.2.	Ашгийн татвар	мян.төг	18,031.1		18,031.1	-	
	4.3.	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	162,280.3	(7,709,580.9)	7,871,861.2	(4,750.8)	
5	5.1.	Нийт ажилчдын тоо	Хүн	148.0	132.0	16.0	89.2	
	5.2.	Үндсэн цалингийн сан	мян.төг	3,425,409.0	4,487,305.0	(1,061,896.0)	131.0	
	5.3.	Ажилтны дундаж сарын цалин	мян.төг	1,928.7	2,832.9	(904.2)	146.9	
6	Хөрөнгө оруулалт		мян.төг	3,960,460.0	2,085,385.8	1,875,074.2	52.7	
	6.1.	Барилга байгууламж	мян.төг	442,000.0	59,000.0	383,000.0	13.3	
	6.2.	Тоног төхөөрөмж	мян.төг	3,518,460.0	2,026,385.8	1,492,074.2	57.6	
	Нийт авлага		мян.төг	39,635,000.0	81,604,120.0	(41,969,120.0)	205.9	
7	7.1.	Хүнсний улаанбуудай	мян.төг	19,635,000.0	16,298,260.0	3,336,740.0	83.0	
	7.2.	Үрийн буудай	мян.төг	4,000,000.0	1,032,900.0	2,967,100.0	25.8	
	7.3.	Бусад хэлбэрээр	мян.төг	16,000,000.0	64,272,960.0	(48,272,960.0)	401.7	
8	Нийт өглөг		мян.төг	26,336,860.0	8,008,121.8	18,328,738.2	30.4	
	8.1	Хөгжлийн банкны зээл	мян.төг	16,050,000.0	3,444,404.1	12,605,595.9	21.5	
	8.2	Төсөв болон дамжуулангийн зээл	мян.төг	10,286,860.0	4,563,717.7	5,723,142.3	44.4	
	Бусад орлого татаас			-	36,027,496.8	(36,027,496.8)		

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 107,293.0 сая төгрөгийн 9 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд төрийн өмчийн хувь оролцооны 81,130.2 сая төгрөгийн үлдэгдлийг нэмж төлөгдсөн капитал дансны үлдэгдлээр, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүний нэмэгдэл 13,162.4 сая төгрөгийг дутуу тайлагнасан.	1	94,292,697.0			1	94,292,697.0	1	94,292,697.0				
Санхүүгийн байдлын тайланд дансны авлагын үлдэгдлийг 1,283.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	1,283,601.5			1	1,283,601.5	1	1,283,601.5				
Санхүүгийн байдлын тайланд бараа материалын үлдэгдлийг 88.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	88,433.8	1	88,433.8			1	88,433.8				
Зээлийн гэрээний алдангийн 521.9 сая төгрөгийн төлбөрийг дутуу хуримтлуулж бүртгэсэн.	1	521,894.3	1	521,894.3			1	521,894.3				
Санхүүгийн байдлын тайланд богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг 5,969.4 сая төгрөг, урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг 22.9 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	5,992,203.9	1	5,992,203.9			1	5,992,203.9				
Орлогын дэлгэрэнгүй тайланд нийт орлогыг 247.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,838.6 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	5,085,921.3	1	5,085,921.3			1	5,085,921.3				
Тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгийн ашиглах жилийг 60, 28 жил гэх зэргээр буруу бүртгэж, элэгдлийн зардлыг 28.2 сая төгрөгөөр буруу тооцоолсон.	1	28,229.5			1	28,229.5	1	28,229.5				
Дүн	9	107,292,981.3	4	11,688,453.2	5	95,604,528.0	7	107,292,981.3	2	-	2	-

3.2 Аудитаар нийт 123,148.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 111,755.6 сая төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлж, 11,393.0 сая төгрөгийн 17 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Үүнээс											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Компанийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуй нэгжид мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгээгүй, жилийн эцсийн санхүүгийн тайланг зэрэгцүүлэх үзүүлэлтээр тайлагнаагүй, тайлангийн тодруулгыг иж бүрэн бэлтгэж толилуулаагүй, хуульд заасан хугацаанд иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй байна.	1	-			1	-						
2	“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК " Б" ХХК-ийн хооронд 2024.04.17-ны өдөр 4854.09 тн хүнсний улаанбуудайг 4,934.9 сая төгрөгөөр худалдах АҮ/65 дугаартай гэрээг, 2024.07.29-ний өдөр 2600 тн хүнсний улаанбуудайг 2,548.0 сая төгрөгөөр худалдах АҮ/102 дугаартай гэрээг байгуулснаас, 7,273.3 сая төгрөгийн гэрээний төлбөр хугацаандаа төлөгдөөгүй шүүхийн маргаан үүсгэсэн, гэрээний хугацаа хэтэрсэн хоног тутамд тооцсон 3,651.0 сая төгрөгийн алдангийн дүнгээр санхүүгийн тайланд орлого хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	1	10,924,336.5			1	10,924,336.5						
3	Тайлант онд аж ахуйн нэгж байгууллагын хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрт БЗД-ийн 4-р	1	1,412,220.1			1	1,412,220.1						

	хороонд байрлах 89м2 3 өрөө орон сууц, 16м2 автозогсоол, БЗД-ын 5-р хороонд байрлах 768м.кв үйлдвэрлэлийн зориулалттай 2 давхар тоосгон барилга, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчлөлийн 700 м.кв 4 газар зэрэг нийт 1,412.2 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, газар хүлээн авсныг өмчлөх эрхийн гэрчилгээг байгууллагын өмчлөлд бүртгүүлж, шилжүүлэн аваагүй байна.											
4	Тайлант компанийн шинээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд 9,110.9 сая төгрөгийн ХАА-н техник, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, шилмэл үүлдрийн үхэр худалдан авалтыг гадаадын 7, дотоодын 1 аж ахуйн нэгж байгууллагатай, 9,279.0 сая төгрөгийн 6,046 тн үрийн улаанбуудайн худалдан авалтыг дотоодын 3 аж ахуйн нэгж байгууллагатай шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн, гэрээний мэдээлэл, шууд гэрээ байгуулсан үндэслэл зэргийг Авлигатай тэмцэх газарт мэдэгдээгүй байна.	1	18,389,883.8			1	18,389,883.8					
5	Сангийн яам ХХААХҮЯ (тухайн үеийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам) хооронд 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан "ХАА-н бага оврын трактор худалдан авах", "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан гэрээнд 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр гэрээг шинэчлэн байгуулж, 2020 оны 04 дүгээр сарын 15-ний өдрөөрх үндсэн төлбөрийн үлдэгдэл 38,706.479.74 ам.долларыг төгрөгт шилжүүлэн 107,699.2 сая төгрөг, зээлийн хүүгийн хэмжээг 6.0 хувь болгон өөрчилж, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлийн сүүлийн төлөлт 2023 оны 03-р сарын 30-ны байхаар заасан боловч 2024 оны жилийн эцсийн байдлаар үндсэн зээлийн 98,398.8 сая төгрөгийн, хүүгийн төлбөрийн 18,280.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	40,479,437.1			1	40,479,437.1					

6	Монгол Улс ба БНХАУ-ын Экспорт импорт банк хооронд байгуулсан "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-ийн 201725451 дугаартай зээлийн гэрээний хүрээнд Сангийн яам ХХААХҮЯ хооронд 2020 оны 4-р сарын 27-ны өдөр байгуулсан "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-ийн зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх 42 дугаартай Хөдөө аж ахуйн техник, трактор худалдан авах 20,198.0 сая төгрөгийн, Усалгааны тоног төхөөрөмж, хоолой худалдан авах 44,916.1 сая төгрөгийн 2 багц бүхий гэрээний 2024 оны хуваарьт төлөлт болох үндсэн зээлийн 7,234.9 сая төгрөг, хүүгийн 3,798.3 сая төгрөгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй байна.	1	11,033,243.0			1	11,033,243.0					
7	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс тус компани Ди Би Эм лизинг ХХК-ийн хооронд "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах " ӨТБГ-23/01 дугаартай гэрээний үүргийн хүрээнд тайлант хугацаанд 3,444.4 сая төгрөгийн төлбөрийг гүйцэтгэж, 1,105.7 сая төгрөгийн алдангийн төлбөр нэмэгдэж жилийн эцсийн байдлаар 29,489.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна	1	29,489,402.8			1	29,489,402.8					
8	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 5 нэр төрлийн 78 ширхэг, нийт 2,570.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг иргэн, хуулийн этгээдэд 7 жилийн хугацаатай түрээслүүлж, гэрээний хугацаа дууссан боловч, тоног төхөөрөмжийг буцаан аваагүй байна.	1	-			1	-					
9	Тайлант онд аж ахуйн нэгж байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөрт хүлээн авсан 15.5 сая төгрөгийн дансны үнэ бүхий 8 толгой үхэр дутагдсаны шалтгаан нөхцлийг бүрэн тогтоогүй байна.	1	15,500.0			1	15,500.0					
10	Бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй Хөтөл салбарын эзэмшлийн гахайн өвлийн байрны зориулалттай 4730 м.кв талбайтай	1	11,620.0			1	11,620.0					

	газрын эзэмших эрхийг хүчингүй болгосон, мөн төмс, хүнсний ногооны зориулалттай 1.8 га талбайтай, нийт 11.6 сая төгрөгийн газрыг хувь хүний нэр дээр бүртгэлтэй байна.												
11	Тайлант онд шинээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд Франц улсын S.A.S Montbeliarde Du jura компаниас 192 үржлийн гунжин үхэрийг 729,760.00 еврогоор худалдан авах гэрээг байгуулан 2,235.1 сая төгрөгийг шилжүүлснээс, 1,064.8 сая төгрөгийн 92 үхрийг хүлээн авч, нийлүүлэгч талд малын өвчин гарсан гэсэн шалтгаанаар гэрээний үүрэг бүрэн хангагдаагүй, 1,170.3 сая төгрөгийг урьдчилж гарсан тооцоо дансанд бүртгэсэн байна.	1	1,170,296.8					1	1,170,296.8				
12	Компанийн тайлант оны үрийн болон тэжээлийн улаанбуудайн борлуулалтын гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс үрийн улаанбуудайн 3,837.8 сая төгрөг, тэжээлийн улаанбуудайн 3,985.9 сая төгрөгийн төлбөр гүйцэтгэгдээгүй, авлагын үлдэгдэлтэй байна	1	7,823,686.9					1	7,823,686.9				
13	Гүйцэтгэх захирлын 2024 оны А/217 дугаар тушаалаар Өрхөтийн ургац ХХК -ийн хугацаа хэтэрсэн 72.2 сая, Ти Эн Эс Эн Ти ХХК-ийн 447.0 сая төгрөг, нийт 519.2 сая төгрөгийн өр төлбөрт 5 тонны даац бүхий Isuzu маркийн крантай автомашиныг 115.0 сая төгрөгөөр, 2024 онд импортоор орж ирсэн Тоёота Ланд крузер 300 VX маркийн автомашиныг 347.0 сая төгрөгөөр, LY928 маркийн 2 тонны даац бүхий 2 ковшийг 57.2 сая төгрөгөөр тус тус тооцож хүлээн авсныг хөрөнгийг орлогоор бүртгэж, харилцагчийн авлагын үлдэгдлээс бууруулаагүй байна.	1	519,232.8					1	519,232.8				
14	Зээлийн модуль, санхүүгийн программ боловсруулах зөвлөх үйлчилгээний ХААКТӨХХК/2023/08009 дугаартай 419.7 сая төгрөгийн гэрээг “М” ХХК-тай 2024.02.19-ний өдөр байгуулж, гэрээний тусгай нөхцөлийн 2.3-д ажлын гүйцэтгэлийн хүлээн авах хугацааг 2024 оны 08-р сарын 31-ны өдөр байхаар заасан	1	419,650.0					1	419,650.0				

	боловч зөвлөх үйлчилгээний ажлыг эцсийн байдлаар бүрэн хүлээж аваагүй байна.												
15	Нөөцийн бараа дансанд бүртгэлтэй өмнөх оны 4,373.9 сая төгрөгийн бараа материал, тайлант онд шинээр худалдан борлуулах зорилгоор 689.6 сая төгрөгийн үр тарианы 10 Силос, 1,800.1 сая төгрөгийн 4 төрлийн Ургамал хамгааллын бодис, 597.9 сая төгрөгийн 2 ширхэг өөрөө явагч ангилан хадагч, нийт 3,087.6 сая төгрөгийн хөрөнгө, бордоог нэмж бэлтгэсэн боловч хөрөнгө, бараа материалыг худалдан борлуулаагүй, хөрөнгийг зах зээлийн тооцоо судалгаанд үндэслэн бэлтгээгүй, хөрөнгүүдийн хадгалалтын горим алдагдвал хөрөнгө үнэгүйдэх, технологийн шаардлага хангахгүй болох зэрэг эрсдэлүүдийг бий болгож байна.	1	-					1	-				
16	Хугацаа хэтэрсэн зээлийн өрөнд авсан Toyota маркын 2 суудлын автомашиныг худалдан борлуулахгүйгээр компанийн үйл ажиллагаанд ашиглаж байна.	1	131,700.0					1	131,700.0				
17	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд зарим хөрөнгийн нэр, байршил, хэмжээ, бүртгэлийн дугаар, нэгж талбарын дугаарыг бичээгүй, ижил нэршлээр тодорхой бус бүртгэсэн, улаанбуудайн хэмжих нэгжийг программд тн болон кг зэргээр өөр нэгжээр бүртгэж тайлагнасан байна.	1	-					1	-				
18	Жилийн эцэст эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллогын комисс томилж, гүйцэтгэсэн боловч, хүнсний болон үрийн улаанбуудайн тооллогын үр дүнг тооцоо бодож, нягтлан бодох бүртгэлээрх үлдэгдэлтэй тохируулаагүй байна.	1	-					1	-				
19	Компанийн ТУЗ-ийн гишүүдийн гадаад албан томилолтын зардалд 17.5 сая төгрөгийг зарцуулсан, компанийн үндсэн хөрөнгийн дансанд 127.0 сая төгрөгөөр бүртгэлтэй Тоёота Ланд Круйзер 200 маркийн автомашиныг ТУЗ-ийн даргын албан хэрэгцээнд ашиглуулж байна.	1	144,501.9					1	144,501.9				
20	Компанийн санхүүгийн тайланд 440.3 сая төгрөгийн тодорхой бус өр төлбөрийн үлдэгдэл	1	440,334.5					1	440,334.5				

	бүртгэлтэй байгааг анхан шатны баримттай тулган баталгаажуулаагүй.												
21	Компанийн 2024 оны эдийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс 22,342.0 сая төгрөг буюу 30.7 хувиар, туслах үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс 16,663.5 сая төгрөг буюу 61.2 хувиар дутуу биелсэн, шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зах зээл, үр ашгийн дэлгэрэнгүй тооцоо судалгааг бүрэн боловсруулаагүй, гүйцэтгэлийг жилийн эцсийн санхүүгийн тайлантай уялдуулж иж бүрэн тайлагнаагүй байна.	1	-					1	-				
22	Гүйцэтгэх захирлын 2024 оны А/98 дугаар тушаалаар Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан боловч компанийн бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт тохируулж боловсруулаагүй байна.	1	-					1	-				
23	Компаниас олгосон зээлийн гэрээний үүргийн дагуу үүссэн хүү, алдангийг санхүүгийн программаар тооцоолж, нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийгээгүй байна.	1	-					1	-				
24	Анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 743.6 сая төгрөгийн ажил, гүйлгээг бүртгэсэн байна	1	743,562.8					1	743,562.8				
	Дүн	24	123,148,609.0	-	-	10	111,755,643.3	14	11,392,965.7	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 5,125.8 сая төгрөгийн зөрчил илэрч, түүнд 5,125.8 сая 5 албан шаардлага, 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Албан шаардлага		Үүнээс Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, Байгууллагын батлагдсан төсөв, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 4 мэдээллийг хугацаа хоцроож, тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлт, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2,988.5 сая төгрөгийн 84 зарлагын гүйлгээ, "Нүүлгэлтийн зардал гаргах тухай" 1,816.7 сая төгрөгийг зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	4,805,206.0	1	4,805,206.0				
Дүн	1	4,805,206.0	1	4,805,206.0				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Захиалагчийн тендерийн баримт бичигт заасан техникийн болон туршлагын шаардлагыг бүрэн хангаагүй аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулж, 290.6 сая төгрөгийн 4 оролцогчтой гэрээ байгуулсан байна. /Тухайлбал:Аудитаар баталгаажуулсан сүүлийн 3 хүртэлх жилийн санхүүгийн тайлан ирүүлээгүй, техникийн болон гүйцэтгээчийн шаардлагыг хангасан материал байхгүй, ижил төстэй ажил	1	290,600.0	1	290,600.0				

гүйцэтгэсэн ажлын туршлага нь нэг эзэмшигчтэй компани хооронд гэрээ байгуулж, акт үйлдсэн кампанийг шалгаруулсан/								
Үнэлгээний хорооны гишүүдийн үнэлгээний хороонд ажиллахыг зөвшөөрсөн мэдэгдэлгүй, хараат бус гишүүдийн АСЗМ-ийн нөхөж бөглөсөн, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үнэлгээний хорооны гишүүдийг бүрэн оролцуулаагүй, оролцоогүй гишүүнийг сонгож үнэлгээний хороог шинээр зохион байгуулаагүй, тушаал шийдвэр гаргаж гишүүнийг шинээр томилоогүй байна. Мөн үнэлгээний хорооны гишүүд тендерийг хянан үзэх маягтыг бүрэн бөглөөгүй байна.	1	-	1	-				
Камержуулалтын 30.0 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн.	1	30,000.0	1	30,000.0				
Тендерт оролцсон оролцогчдод тендерт шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлэхдээ гэрээ байгуулах эрх олгосон оролцогчийн нэр, гэрээ байгуулах үнийг мэдэгдээгүй.	1	-	1	-				
Өмнөх оны аудитаар өгсөн “Компанийн санхүүгийн тайлан, тодруулгыг батлагдсан маягт, заавар аргачлалын дагуу бэлтгээгүй, хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад аудит хийлгүүлэхээр хүргүүлээгүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх”, “Тухайн салбарт төрөөс баримталж байгаа бодлого, зохицуулалтаас болон дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын хугацаа хэтрэлтээс шалтгаалан үндсэн зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх”, “Компанийн төлбөрийн чадварт үндэслэн өр төлбөр барагдуулах гэрээний эргэн төлөлтийн хуваарийг байгуулаагүйгээс гэрээний үүрэг хангагдаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх”, Түрээслэгчтэй байгуулсан “Тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ”-г дүгнэж, тооцоо хийгээгүй, тоног төхөөрөмжийг буцаан хүлээн аваагүй зөрчлийг арилгах”, “Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, хянуулаагүйгээс Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх” зэрэг 5 албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	-			1	2		
Хугацаа хэтэрсэн зээл, авлагын үлдэгдлийг барагдуулах ажлын хүрээнд зээлдэгч нараас өр төлбөрт бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч эргэлтийн хөрөнгөд бүртгэж ирсэн ч, хөрөнгийг үр ашигтай худалдан борлуулж, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй нь хөрөнгийн үнэ цэнэ буурах, зардал нэмэгдэх, үрэгдэх зэрэг эрсдэлийг бий болгож байна. Мөн гүйцэтгэх захирлын 2024 оны А/247 дугаар тушаалаар баталсан "Өр төлбөрт бараа	1	-					1	-

бүтээгдэхүүнийг үнэлэн авах, худалдан борлуулах журам"-ын зарим, зүйл заалт нь хөрөнгийг компанийн үйл ажиллагаанд ашиглах, ажилтны нийгмийн асуудлыг шийдэх зэрэгт зарцуулах боломжийг нээж, нөгөө талдаа хугацаа хэтэрсэн өр төлбөрийг бууруулах арга хэмжээ үр дүнгүй болгох сөрөг талтай байна.								
.								
“ХААК” ТӨХХК нь газар тариалангийн бүс нутагт түшиглэсэн 6 салбарт нийт 180 мянган тонн үр тариа хадгалах зориулалт бүхий элеватор, агуулахыг эзэмшиж, улаанбуудай, малын тэжээлийн нөөцийг бүрдүүлж байгаа боловч тус элеваторуудын дулаан мэдрэгч, жингийн хэмжигч зэрэг нь ажиллахаа больсон нь хадгалалтын үеийн үзүүлэлтүүдэд тавих хяналт сулрах, чанар байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэхээр байна.	1	-					1	-
Компанийн ТУЗ болон аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлагнал, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	1	-					1	-
Дүн	8	320,600.0	4	320,600.0	1	2	3	-
Нийт дүн	9	5,125,806.0	5	5,125,806.0	1	2	3	-